



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/742

Булган сум

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7, 9.3.10 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2023 оны XVII/01 тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвийн 11-11 төвд Хутаг-Өндөр сумын 2 дугаар багийн иргэнээс ирүүлсэн нэршил нь үл мэдэгдэх хорт бодис байгаа газарт мал хордож үхэж байгаа гомдлын дагуу Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт Шинжлэх ухааны академийн хими, химийн технологийн хүрээлэнд усны дээжийн шинжилгээний – 1, хөрсний дээжийн шинжилгээний – 3 дээжид химийн шинжилгээ хийлгэхэд шаардагдах 390,000 (гурван зуун ерэн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Хутаг-Өндөр сумын 2 дугаар багийн усны, хөрсний дээжийн шинжилгээний ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавин ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын дарга (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

3.Тус арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх сангийн “Цэвэр орчин – цэмцгэр булган” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

